



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/89

Төгөл

**Ой хээрийн түймрээс урьдчилан
сэргийлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 31 дүгээр зүйлийн 31.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйл, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйл, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5, байгаль орчны аялал жуулчлалын сайдын А/184 тушаал, Аймгийн онцгой комиссын 02 албан даалгавар тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулж түймэр гарах магадлал бүхий газруудад 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдрийг хүртэл, 09 дүгээр сарын 20-ний өдрөөс 11 дүгээр сарын 10-ний өдрийн хооронд эргүүл жижүүрийг тус тус ажиллуулж хяналт шалгалтыг тогтмол хийж ажиллахыг Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (М.Отгонбаатар), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Батчимэг), Байгаль хамгаалагч (Ө.Нямгэрэл), (Б.Ганцэцэг) болон 6-н багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

2. Дээрх хугацаанд түймрийн эргүүлийг 6 баг дээр томилгоожуулж, ажиллах мэргэжил аргагүйгээр ханган ажиллахыг Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (М.Отгонбаатар)-т даалгасугай.

3. Заасан хугацаанд цаг агаарын болон хуурайшилтын мэдээг байнгын мэдээлж ажиллахыг Цаг уурч (Б.Өсөжаргал)-д үүрэг болгосугай.

4. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах бэлэн байдлыг хангах чиглэлээр сургалт, сурталчилгааг ард, иргэд аж ахуйн нэгж болон мэргэжлийн ангиудад тогтмол явуулж ажиллахыг Гамшгаас хамгаалах штабын дарга (М.Батцогт), БОТХБ-ын тасгийн дарга (М.Отгонбаатар), СДОА-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бямбацогт), хэсгийн төлөөлөгч (Б.Батзаяа) нарт тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Тамгын газрын дарга (М.Батцогт)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.БАТБАЯР

/Zahiramj/